

НЭГДСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэ журмын зорилго нь Банкны тухай хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн шаардлага болон бусад шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх, 37 дугаар зүйлд заасан банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайлан гаргах харилцааг тодорхойлоход тус тус оршино.
- 1.2 Журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.2.1 “Банк” гэж Банкны тухай хуулийн 3.1.1-д заасныг;
 - 1.2.2 “Банкны нэгдэл” гэж Банкны тухай хуулийн 3.1.6-д заасныг;
 - 1.2.3 “Банкны нэгдлийн асуулга” гэж банкны нэгдлийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, түүний санхүү, төлбөрийн чадвар, оролцогч хоорондын хөрөнгийн урсгал, өглөг, авлага, зээл болон бусад үүрэг, хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар мэдээлэл авах зорилго бүхий асуулгыг;
 - 1.2.4 “Банкны нэгдлийн оролцогч” гэж Банкны тухай хуулийн 3.1.7-д заасныг;
 - 1.2.5 “Нэгдсэн хяналт шалгалт” гэж Банкны тухай хуулийн 3.1.8-д заасныг;
 - 1.2.6 “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэж банкны нэгдлийн оролцогч тус бүрийн болон банкны нэгдэл нэгдсэн байдлаар санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг;
 - 1.2.7 “Холбогдох этгээд” гэж Банкны тухай хуулийн 3.1.2 -т заасныг;
 - 1.2.8 “Банкны нэгдлийн оролцогч хоорондын хэлцэл, гүйлгээ” гэж банкны нэгдлийн нэг оролцогч нөгөө оролцогчдоо зээл олгох, өглөг, авлага үүсгэх, аль нэг оролцогчийн гаргасан үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө худалдан авах, аль нэг оролцогчийн эрх ашгийн тулд батлан даалт гаргах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцэл болон санхүүгийн бусад үүрэг, шаардах эрх үүсгэх хэлцэл/гүйлгээг;
 - 1.2.9 “Холбогдох этгээдтэй хийх хэлцэл, гүйлгээ” гэж банкны нэгдлийн оролцогч банк тухайн банкны нэгдлийн холбогдох этгээдэд зээл олгох, өглөг, авлага үүсгэх, аль нэг оролцогчийн гаргасан үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө худалдан авах, аль нэг оролцогчийн эрх ашгийн тулд батлан даалт гаргах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцэл болон санхүүгийн бусад үүрэг, шаардах эрх үүсгэх хэлцэл/гүйлгээг;

**ЖУРМЫН ТӨСӨЛ
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ**

- 1.2.10 “Зээл” гэж гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгийг;
 - 1.2.11 “Бусад актив” гэж зээлтэй адилтган тооцохуйц зээлээс бусад тэнцэл дэх актив, Төв банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цааснаас бусад төрлийн үнэт цаас, тэнцлийн гадуурх баталгаа, батлан даалт, аккредитив, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хэлцлийн дагуу хүлээж болзошгүй үүрэг зэрэг банкны үйл ажиллагаатай холбоотойгоор ирээдүйд банкинд шаардах эрх, авлага буюу активын эрсдэл үүсгэхээр байгаа үүргийг;
 - 1.2.12 “Санхүүгийн байгууллага” гэж Банкны тухай хуулийн 6.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1, Даатгалын тухай хуулийн 4.1.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.1, Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1 -д тус тус заасан үйл ажиллагааг эрхлэгч этгээдийг;
 - 1.2.13 “Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага” гэж Банкны тухай хуулийн 3.1.11-д заасныг;
 - 1.2.14 “Гүйцэтгэх удирдлага” гэж Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасныг;
 - 1.2.15 “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар гэж” Монголбанкнаас баталсан Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг хэлнэ.
- 1.3 Банкны нэгдэл нь энэхүү журмыг мөрдөнө.
 - 1.4 Банкны нэгдэл нь нэгдсэн хяналт шалгалт хийхэд хүндрэл учруулахааргүй, ойлгомжтой, ил тод бүтэц, зохион байгуулалттай байна.
 - 1.5 Нэгдсэн хяналт шалгалт нь банкинд хийх ганцаарчилсан хяналт шалгалтыг орлохгүй.
 - 1.6 Нэгдсэн хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчмын дагуу хэрэгжүүлнэ.
 - 1.7 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн хяналт шалгалтын талаар хүлээх үүрэг, хариуцлагыг энэ журмаар зохицуулах бөгөөд журамд хамрагдаагүй асуудлуудыг харилцан ойлголцлын санамж бичиг болон тэдгээрийг зохицуулсан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

ХОЁР. БАНКНЫ НЭГДЛИЙН УДИРДЛАГА

- 2.1 Банкны нэгдлийн толгой компани нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.
- 2.2 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2/5 буюу түүнээс дээш хувь нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх бөгөөд нэгдлийн оролцогч банкны Гүйцэтгэх удирдлага байж болно.
- 2.3 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэг хараат бус гишүүн нь Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

- 2.4 Банкны нэгдлийн толгой компанийн Гүйцэтгэх удирдлага нь Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 2.5 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага шинээр томилогдох, солигдох бүрт Хавсралт 1 -ийн дагуу шинээр томилогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагын тодорхойлолтыг Монголбанкинд ирүүлж, зөвшөөрөл авна.
- 2.6 Банкны нэгдлийн толгой компани болон нэгдлийн оролцогчдын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, дотоод хяналт хариуцсан нэгжийн удирдлага нь Санхүүгийн хянан шалгах эрх бүхий байгууллагуудтай холбоотой ажиллаж, шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

ГУРАВ. БАНКНЫ НЭГДЛИЙН ТОЛГОЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ

- 3.1 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам болон энэ журмын дагуу эрх, үүрэг хүлээж, үйл ажиллагаагаа явуулна.
- 3.2 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны нэгдлийн хэмжээнд эрсдэл даах сонирхолыг (risk appetite) тодорхойлж, банкны нэгдлийн ерөнхий бодлого, стратеги, энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсруулж, нэгдлийн хэмжээнд болон оролцогч компаниудад зориулсан зохистой засаглалын оновчтой бүтцийг нэвтрүүлэн хяналт тавьж ажиллана.
- 3.3 Банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны нэгдэл, толгой компани, оролцогч компаниудын хэмжээ, үйл ажиллагааны боловсронгуй байдал, эрсдэлийн төлөвтэй нийцсэн байгууллагын бүтэц, дотоод хяналтын тогтолцоо, удирдлагад тайлагнах тогтолцоог бүрдүүлж, хяналт тавина.
- 3.4 Банкны нэгдлийн оролцогч хооронд болон холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээдтэй гэрээ, хэлцэл, гүйлгээ хийх харилцааг зохицуулсан бодлого, журам болон гэрээ, хэлцэл, гүйлгээ хийхэд баримтлах ёс зүйн дүрмийг банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж, хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.5 Банкны нэгдлийн хэмжээнд нэгдлийн оролцогч хоорондын ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийхээс зайлсхийх, ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээг тодорхойлох, холбогдох арга хэмжээ авах харилцааг зохицуулсан дотоод журмыг банкны нэгдлийн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл баталж, хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.6 Банкны нэгдлийн Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны нэгдлийн гадаад дахь үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, зохистой үйл ажиллагаанд хяналт тавьж холбогдох тайлан, мэдээллийг аливаа саадгүй, түргэн шуурхай авдаг байх тогтолцоог бүрдүүлж, хяналт тавьж ажиллана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

- 4.1 Банкны нэгдэл нь өөрийн эрсдэл даах сонирхол, эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, дотоод хяналтыг үр ашигтай, найдвартайгаар хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, нөхцөл боломж, боловсон хүчнээр хангагдсан байна.
- 4.2 Банкны нэгдэл нь эрсдэлийг (зах зээлийн, зээлийн, үйл ажиллагааны, стратегийн, хөрвөх чадварын гэх мэт) илрүүлэх, үнэлэх, хянах, удирдах, холбогдох өөрийн хөрөнгийн нөөц үүсгэх талаар тусгасан дотоод журам, арга, аргачлалтай байна.
- 4.3 Банкны нэгдэл нь нэгдлийн бүтэц, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог болон боловсронгуй байдлаас хамааруулан банкны нэгдлийн голлох эрсдэлүүдэд сорил, мэдрэмтгийн байдлын шинжилгээг тодорхой давтамжийн дагуу тогтмол хийж, удирдлагад тайлагнана.
- 4.4 Банкны нэгдэл нь эрсдэлийн үнэлгээг цаг тухай бүрд оновчтой хийж, холбогдох өөрийн хөрөнгийн нөөц үүсгэн өөрийн хөрөнгийн хүрэлцээг ханган ажиллаж байгаа эсэх, эрсдэлийн сорил, мэдрэмтгий байдлын шинжилгээг тогтмол, үр ашигтай хийж байгаа эсэхэд дотоод хяналтын нэгж хяналт тавьж, удирдлагад тайлагнана.
- 4.5 Банкны нэгдэл шинэ төрлийн үйл ажиллагаа эхлүүлэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхдээ эрсдэлийн шинжилгээг хийж, эрсдэлийн төлөв болон чадамжтай уялдуулан шийдвэр гаргадаг байна.
- 4.6 Банкны нэгдлийн аливаа үйл ажиллагааг хөндлөнгийн компаниар гүйцэтгүүлэх (outsource) тохиолдолд холбогдох эрсдэлийн шинжилгээг хийж, шийдвэр гаргадаг байна.

ТАВ. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 5.1 Банкны нэгдэл нь өөрийн хөрөнгийг зохистой хэмжээнд байлгах дотоод бодлого, өөрийн хөрөнгийг үнэлэх арга, аргачлалтай байна.
- 5.2 Банкны нэгдэлд өөрийн хөрөнгийн давхар бичилт буюу нэг өөрийн хөрөнгийг хэд хэдэн нэгдлийн оролцогч давхардуулан өөрийн хөрөнгөд тооцохыг хориглоно.
- 5.3 Банкны нэгдлийн толгой компани болон оролцогчид нь өр болон зээлийн эх үүсвэрээр охин болон хараат компанид хөрөнгө оруулж, түүнийгээ тухайн охин болон хараат компанийн өөрийн хөрөнгөд тооцохыг хориглоно.
- 5.4 Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг банкны нэгдлийн оролцогчдыг дараахь зарчмын дагуу нэгтгэлд хамруулж, банкны нэгдлийн өөрийн хөрөнгийг нэгдсэн байдлаар тооцно. Үүнд:
 - 5.4.1 Толгой компанийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч дахь өмчлөл нь 10 хувиас бага ($\leq 10\%$) байвал тухайн нэгдлийн оролцогчийг нэгтгэлд хамруулахгүй, өөрийн хөрөнгөөс хорогдуулалт хийхгүй, тухайн оролцогчид оруулсан хөрөнгө оруулалтыг толгой компанийн эрсдэлтэй активт тооцож, холбогдох эрсдэлээр жигнэнэ.

ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

- 5.4.2 Толгой компанийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч дахь өмчлөл нь 10-20 хувь ($10\% \leq 20\%$) байвал тухайн нэгдлийн оролцогчийг нэгтгэлд хамруулалгүй оруулсан хөрөнгө оруулалтыг нийт өөрийн хөрөнгөөс хорогдуулах эсвэл сайн дурын үндсэн дээр хувь тэнцүүлэн (pro-rata) нэгтгэлд хамруулна.
- 5.4.3. Толгой компанийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч дахь өмчлөл нь 20-50 хувь ($20\% \leq 50\%$) бөгөөд мэдэгдэхүйц хяналт үзүүлж байвал бүрэн хэмжээгээр нэгтгэлд хамруулна. Мэдэгдэхүйц хяналт байхгүй тохиолдолд хувь тэнцүүлэн (pro-rata) нэгтгэлд хамруулна.
- 5.4.4. Толгой компанийн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч дахь өмчлөл нь 50 хувиас их ($>50\%$) байгаа бөгөөд дийлэнх саналын эрхтэй байвал бүрэн хэмжээгээр нэгтгэлд хамруулна.
- 5.4.5 Санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогчийг нэгтгэлд хамруулахгүй бөгөөд тухайн оролцогч дахь толгой компанийн өмчлөл нь 20 хувиас бага ($<20\%$) байвал тухайн оролцогчид оруулсан хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөс хорогдуулалт хийхгүй, эрсдэлтэй активт тооцож, холбогдох эрсдэлээр жигнэнэ. Хэрэв өмчлөл нь 20 хувиас их ($\geq 20\%$) байвал тухайн оролцогчид оруулсан хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөс хорогдуулна.
- 5.4.6 Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг банкны нэгдлийн оролцогчийг нэгтгэлд хамруулахгүй бөгөөд толгой компанийн өөрийн хөрөнгөөс хорогдуулна.
- 5.4.7 Монголбанкнаас нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн нэгдлийн оролцогчийг нэгтгэлд хамруулна.
- 5.5 Банкны нэгдлийн толгой компани нь санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалтгүй хуулийн этгээд байх тохиолдолд өөрийн хөрөнгийг нэгдсэн байдлаар тооцохгүй.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 6.1 Банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг банкны нэгдлийн оролцогчид нь тус бүр өөрийн хамааралтай Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.
- 6.2 Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг толгой компанитай банкны нэгдэл нь “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу дараахь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар тооцож ажиллана:
- 6.2.1 өөрийн хөрөнгийн хүрэлцээний;
 - 6.2.2 төлбөр түргэн гүйцэтгэх чадварын;
 - 6.2.3 гадаад валютын ханшийн эрсдэлийн.

ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

- 6.3 Банкны нэгдлийн энэ журмын 6.2-т заасан зохистой харьцааны үзүүлэлтүүд нь тухайн нэгдлийн толгой компанийн харьяалагдах Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шаардлагаас багагүй байна.
- 6.4 Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг энэ журмын 5.4-д заасан зарчмын дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр Хавсралт 3-д заасан Блок үүсгэх арга (Building Block Prudential Approach), Эрсдэлд суурилсан нэгтгэлийн арга (Risk-Based Aggregation), Эрсдэлд суурилсан хорогдуулалтын арга (Risk-Based Deduction Method) -ын аль нэгийг ашиглан тооцож гаргана.
- 6.5 Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолохдоо Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас өөрийн хөрөнгийн шаардлага тавьдаггүй нэгдлийн оролцогчийн хувьд өөрийн хөрөнгийн шаардлагын орлуулагч (проху) ашиглах ба орлуулагчийн утгыг Монголбанк тогтооно.
- 6.6 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг банкны нэгдлийн хэмжээнд нэгдсэн байдлаар тооцоход банкны нэгдлийн оролцогч бүрийн хувьд тухайн нэгдлийн оролцогчийн хамааралтай Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тогтоосон эрсдэлээр жигнэх хувийг ашиглана. Зохицуулалтгүй үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогчдын хувьд эрсдэлээр жигнэх хувийн орлуулагч (проху) ашиглан тооцоолох ба орлуулагчийн утгыг Монголбанк тогтооно.
- 6.7 Банкны нэгдлийн эрсдэлээр жигнэсэн активыг тооцоход банкны нэгдлийн оролцогч хоорондын хэлцлийн дагуу үүссэн активыг цэвэршүүлсний дараа эрсдэлээр жигнэнэ.
- 6.8 Энэ журмын 6.2-т заасан банкны нэгдлийн зохистой харьцааны шаардлагыг энэ журмын 6.3-т зааснаас ялгаатайгаар Монголбанк дангаараа эсхүл Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоож болно.
- 6.9 Энэ журмын 6.2-т заасан банкны нэгдлийн зохистой харьцааны нэмэлт шаардлагыг Монголбанк дангаараа эсхүл Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоож болно.

ДОЛОО. БАНКНЫ НЭГДЛИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХИЙХ ХЭЛЦЭЛ, ГҮЙЛГЭЭ

- 7.1 Банкны нэгдлийн оролцогч банкны тухайн нэгдлийн аливаа нэг оролцогчтой болон холбогдох этгээдтэй хийх хэлцэл, гүйлгээний дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байх бөгөөд нэгдлийн оролцогчидтой хийх бүх хэлцэл, гүйлгээний нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

- 7.2 Банкны нэгдэл нь нэгдлийн оролцогч хоорондын болон холбогдох этгээдтэй хэлцэл, гүйлгээ хийх харилцааг зохицуулсан дотоод бодлого, журам болон хэлцэл, гүйлгээ хийхэд баримтлах ёс зүйн дүрэмтэй байна.
- 7.3 Нэгдлийн оролцогчид хоорондын болон холбогдох этгээдтэй хийх хэлцэл, гүйлгээ нь найдвартай, зохистой үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.
- 7.4 Банкны нэгдлийн оролцогч хоорондын болон холбогдох этгээдтэй хийх хэлцэл, гүйлгээ нь банкны нэгдлийн бусад этгээдүүдтэй хийх хэлцэл, гүйлгээтэй ижил нөхцөлтэй байна.

НАЙМ. БАНКНЫ НЭГДЛИЙН НЭГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, БУСАД ТАЙЛАН, МЭДЭЭ, АСУУЛГА

- 8.1 Банкны тухай хуулийн 39.1 болон 44.5-д заасны дагуу банкны нэгдлийн оролцогчид болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан нь шаардлагатай тайлан, мэдээ мэдээллийг Монголбанкинд үнэн зөвөөр гаргаж өгөх үүрэгтэй.
- 8.2 Банкны нэгдлийн бүтэц, нэгдлийн оролцогч, холбогдох этгээдийн талаархи мэдээлэл болон тэдгээртэй холбогдолтой оруулсан өөрчлөлт бүрийг өөрчлөлт оруулсан тухай шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор нэгдлийн оролцогч банкаар дамжуулан Монголбанкинд мэдэгдэнэ.
- 8.3 Банкны нэгдлийн хувьд нэгдсэн байдлаар болон банкны нэгдлийн оролцогч тус бүрээр дараахь тайланг улирал бүрийн байдлаар дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор банкны нэгдлийн оролцогч хамгийн том банкаар дамжуулан Монголбанкинд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Үүнд:
 - 8.1.1 Хавсралт 2-ын дагуу бэлтгэсэн дараахь санхүүгийн тайлан. Үүнд:
 - 8.1.1.1 Санхүүгийн байдлын тайлан;
 - 8.1.1.2 Орлогын дэлгэрэнгүй тайлан;
 - 8.1.1.3 Өмчийн өөрчлөлтийн тайлан
 - 8.1.1.4 Мөнгөн гүйлгээний тайлан.
 - 8.1.2 Банкны нэгдлийн хувьд нэгдсэн байдлаар болон банкны нэгдлийн оролцогч тус бүрээр Хавсралт 4-ийн дагуу бэлтгэсэн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тайлан.
 - 8.1.3 Банкны нэгдлийн хувьд нэгдсэн байдлаар болон банкны нэгдлийн оролцогч тус бүрээр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан дараахь тайлан. Үүнд:
 - 8.1.3.1 Том зээлдэгчдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан;
 - 8.1.3.2 Тэнцлийн гадуур бүртгэлтэй батлан даалт, аккредитив, бусад хүлээж болзошгүй үүргийн тайлан;
 - 8.1.3.3 Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан;

8.1.3.4 Гадаад валютын зохистой харьцааны тайлан.

8.1.4 Банкны нэгдлийн оролцогч тус бүрээр Хавсралт 5-ын дагуу бэлтгэсэн Банкны нэгдлийн оролцогч хоорондын хэлцэл, гүйлгээний тайлан.

8.1.5 Банкны нэгдлийн хувьд нэгдсэн байдлаар болон банкны нэгдлийн оролцогч тус бүрээр Хавсралт 5-ын дагуу бэлтгэсэн холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл, гүйлгээний тайлан.

8.1.6 Банкны нэгдлийн оролцогч бүрийн харьяалагдах санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагад хүргүүлсэн тайлангууд болон тухайн тайлант хугацааны биелэлтийн талаар санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн албан бичгийн хуулбарууд.

8.4 Энэ журмын 8.6-ын дагуу нэгдсэн санхүүгийн тайлан гаргахгүй банкны нэгдэлийн хувьд энэ журмын 8.1.1-ийн хүрээнд зөвхөн нэгдлийн оролцогч тус бүрээр тайланг гаргана.

Банкны нэгдлийн асуулга

8.5 Банкны нэгдлийн оролцогч нь Банкны нэгдлийн асуулгыг Хавсралт 6-ийн дагуу тухайн жилийн эцсийн байдлаар дэлгэрэнгүй гарган дараа жилийн эхний сарын дотор нийт активын хувьд хамгийн том оролцогч банкаар дамжуулан Монголбанкинд ирүүлнэ.

8.6 Шаардлагатай гэж үзвэл Монголбанк Банкны нэгдлийн асуулгын дагуу ирүүлсэн аливаа тайлан, мэдээний талаар бусад төр захиргааны байгууллагаас лавлагааг авч, баримтжуулна.

Нэгдсэн санхүүгийн тайлан

8.7 Банкны нэгдлийн толгой компани нь санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байх тохиолдолд банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайлан гаргана.

8.8 Банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайланг ОУНББС болон СТОУС зарчим, банкны нягтлан бодох бүртгэлийн зааврыг баримтлан Банкны тухай хуулийн 37.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байхаар гаргана.

8.9 Банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайланг гаргахдаа энэ журмын 5.4-т заасан зарчмын дагуу нэгдлийн оролцогчдыг нэгтгэлд хамруулан санхүүгийн тайланг гаргана.

8.10 Банкны нэгдлийн жилийн эцсийн аудитлагдсан нэгдсэн санхүүгийн тайланг дараа жилийн эхний улирлын дотор банкны нэгдлийн оролцогч банкаар дамжуулан Монголбанкинд хүргүүлнэ.

8.11 Банк нь банкны нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэх бол Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авна.

8.12 Тухайн тайлант хугацааны банкны нэгдлийн санхүүгийн нэгдсэн тайлан болон нэгдлийн оролцогч банкны санхүүгийн тайланд нэг ижил компаниар аудит хийлгэсэн байна.

- 8.13 Энэ журмын дагуу боловсруулсан нэгдсэн санхүүгийн тайлангууд нь хяналт шалгалтын зориулалттай бөгөөд нягтлан бодох бүртгэлийн зориулалтаар боловсруулсан санхүүгийн тайлангуудаас ялгаатай байж болно.

ЕС. НЭГДСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 9.1 Банкны нэгдлийн оролцогч бүх банк, санхүүгийн байгууллага нэгдсэн хяналт шалгалтад хамрагдана.
- 9.2 Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг банкны нэгдлийн оролцогчийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулж болно.
- 9.3 Банкны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан нөхцөл бүрдсэн бол банкны нэгдлийн оролцогч нэгдсэн хяналт шалгалтад хамрагдахгүй байж болно.
- 9.4 Банкны нэгдлийн оролцогчийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй бол энэ талаар Монголбанк шийдвэр гаргаж, энэ тухайгаа банкны нэгдлийн оролцогч банкинд мэдэгдэнэ.
- 9.5 Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллага, түүний салбар, нэгжийн талаарх нэгдсэн хяналт шалгалтыг тухайн улсын Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын банк, санхүүгийн байгууллагын салбар нэгж, охин компаниудын талаар нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.
- 9.6 Банкны нэгдлийн гадаад улс дахь үйл ажиллагааг нэгдсэн хяналт шалгалтад хамруулж, шаардлагатай тохиолдолд тухайн гадаад улс дахь нэгдлийн оролцогчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Ингэхдээ тухайн улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтарч ажиллана.

АРАВ. НЭГДСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Санхүүгийн хянан зохицуулах байгууллагууд

- 10.1 Монголбанк дангаараа, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийнэ.
- 10.2 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хийх нэгдсэн хяналт шалгалтыг Монголбанк удирдан зохион байгуулна.
- 10.3 Нэгдсэн хяналт шалгалт хийх хянан шалгагч, улсын байцаагч нь Банкны тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тавигдах шаардлагыг хангаж, эрх үүргийг хүлээнэ.
- 10.4 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн банкны нэгдэлд хийх нэгдсэн хяналт шалгалтад оролцох улсын байцаагч, хянан шалгагч, мэргэжилтний нийт тоо нэгдсэн хяналт шалгалтад хамрагдах банкны нэгдлийн оролцогчдын тооноос багагүй байна.

- 10.5 Нэгдсэн хяналт шалгалтын удирдамжийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах бөгөөд удирдамжид нэгдсэн хяналт шалгалтыг хийх ажлын хэсгийн ахлагч болон ажлын хэсгийн гишүүд бүрийн үүрэг хариуцлага, ажил үүргийн хуваарийг дэлгэрэнгүй тусгасан байна.
- 10.6 Нэгдсэн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь Монголбанкны хянан шалгагч/улсын байцаагч байна.

Нэгдсэн хяналт шалгалт хийх

- 10.7 Нэгдсэн хяналт шалгалтыг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 10.7.1 Банкны нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, нэгдлийн оролцогчдын бизнесийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны чиглэл, нэгдэл дэх оролцоог тодорхойлох;
- 10.7.2 Нэгдсэн хяналт шалгалтад хамруулах банкны нэгдлийн оролцогчдыг тодорхойлох;
- 10.7.3 10.8.2-ын дагуу тодорхойлсон нэгдлийн оролцогчдыг нэгтгэлд хамруулах аргачлалыг сонгох (бүрэн нэгтгэлд хамруулах, хувь тэнцүүлэн хамруулах эсвэл хорогдуулах)
- 10.7.4 Хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийг гаргаж, хэрэгжүүлэх;
- 10.7.5 Банкны нэгдлийн болон нэгдлийн оролцогчдын үнэлгээг гаргах буюу нэгдсэн хяналт шалгалтад хамрагдах хэсгийн өөрийн хөрөнгийг нэгдсэн байдлаар тооцох, эрсдэлээр жигнэсэн активыг тооцох, зохистой харьцааг тооцох, эрсдэлийн үнэлгээг хийх;
- 10.7.6 Хяналт шалгалтын үнэлгээнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авах, дараагийн хяналт шалгалтыг товлох, төлөвлөгөөг гаргах.
- 10.8 Нэгдсэн хяналт шалгалт нь газар дээрх шалгалт болон зайнаас тавих хяналт гэсэн үндсэн 2 хэлбэртэй байна.
- 10.9 Газар дээрх шалгалт нь иж бүрэн болон хэсэгчилсэн гэсэн 2 хэлбэртэй байх бөгөөд газар дээрх иж бүрэн шалгалтыг 2 жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.
- 10.10 Банкны нэгдэлд хийх газар дээрх иж бүрэн шалгалт нь дараахь бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:
- 10.10.1 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны өөрийн зохицуулалтад хамаарах байгууллагуудад хийх ээлжит иж бүрэн шалгалт;
- 10.10.2 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтад хамрагддаггүй санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогчид хийх ээлжит иж бүрэн шалгалт;
- 10.10.3 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах байгууллагаар дамжуулан мэдээллийг бүрэн авах боломжгүй санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогчдод хийх хэсэгчилсэн шалгалт;

- 10.10.4 Банкны нэгдлийн үйл ажиллагааг хэрэв нэг хуулийн этгээд буюу толгой компани эсвэл нэгдлийн нэг оролцогч удирдан зохион байгуулдаг бол түүнд хийх иж бүрэн шалгалт.
- 10.11 Зайнаас тавих хяналтыг Монголбанк энэ журмын дагуу банкны нэгдлээс ирүүлэх тайлангууд болон Банкны нэгдлийн асуулгад үндэслэн банкны нэгдэл, нэгдлийн оролцогчийн холбогдох хууль тогтоомж, энэ журам болон Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан бусад журам, заавраар тогтоосон шалгуур, хязгаарлалтуудыг хэрхэн ханган ажиллаж байгаа болон банкны нэгдлийн учирч болзошгүй эрсдэлүүд, санхүү, төлбөрийн чадварын талаар улирал бүр дүгнэлт хийх чиглэлээр хэрэгжүүлнэ.
- 10.12 Санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг банкны нэгдлийн оролцогчийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулахдаа нэгдлийн оролцогч банк эсвэл хамааралтай хянан зохицуулагч байгууллагаар дамжуулан авсан тухайн оролцогчийн санхүүгийн тайлан, банкны нэгдлийн асуулга, нэмэлт тайлбар, бусад тайлан, мэдээллүүдэд үндэслэн банкны нэгдэлд болон нэгдлийн оролцогч банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагаварын үнэлгээ дүгнэлтийг хийнэ.

АРВАН ХОЁР. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 12.1 Банкны нэгдлийн нэгдсэн хяналт шалгалтын хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, мэргэжилтнүүд хоорондоо шаардлагатай холбогдох мэдээллийг солилцоно.
- 12.2 Энэ журмын 12.1-ийн хүрээнд мэдээлэл хүсэгч байгууллага нь тухайн мэдээлэл шаардлагатай болсон шалтгаан, зориулалт болон мэдээллийн хамрах хүрээ, хугацаа зэргийг дэлгэрэнгүй тусгасан албан бичгийг нөгөө байгууллагадаа илгээж, хүсэлт гаргана.
- 12.3 Энэ журмын 12.2-ын дагуу хүссэн мэдээлэл нь нууцад хамаарах, мэдрэмтгий мэдээлэл байх тохиолдолд тухайн мэдээллийг эзэмшигч байгууллага мэдээллийг солилцохоос татгалзаж болно.
- 12.4 Нууцад хамаарах аливаа мэдээллийг грав дагч этгээдэд олгох, нийтэд мэдээлэхдээ энэ талаар нөгөө талдаа албан бичгээр урьдчилан мэдэгдэж, зөвшилцөнө.
- 12.5 Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагууд, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хооронд мэдээлэл солилцоход хуулийн хүрээнд тавигдах хязгаарлалтыг харгалзан үзэх бөгөөд мэдээллийн нууцлалыг хадгална.

АРВАН ГУРАВ. АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН БУСАД

- 13.1 Банкны нэгдэлд албадлагын арга хэмжээг Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 13.2 Банкны нэгдэлд албадлагын арга хэмжээ авахдаа тухайн зөрчилтэй холбоотой банкны нэгдлийн оролцогчид арга хэмжээг төвлөрүүлэн авна.
- 13.3 Банкны нэгдлийн оролцогч нь Монголбанк эсхүл Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарагддаг бол үйл ажиллагаа нь зохицуулагддаг

**ЖУРМЫН ТӨСӨЛ
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ**

хууль эрх зүйн актуудыг үндэслэн шат дараалсан албадлагын арга хэмжээг холбогдох хяналт шалгалтын байгууллага авна.

- 13.4 Санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогчоос нэгдлийн оролцогч банкны хэвийн тогтвортой үйл ажиллагааг алдагдахуйц сөрөг нөлөө үзүүлж байгаа эсхүл үзүүлж болзошгүй, нэр хүндийн эрсдэлд оруулж болзошгүй гэж Монголбанк үзсэн тохиолдолд нэгдлийн оролцогч банкиг нэгдлийн үйл ажиллагаанаас, эсхүл бүтэц зохион байгуулалтаас тусгаарлана.
- 13.5 Банкны нэгдлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх энэхүү журмын биелэлтэд Монголбанкны Хяналт шалгалтын газар, Санхүүгийн зохицуулах хороо, сахүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

**БАНКНЫ НЭГДЛИЙН ӨӨРИЙН
ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийг дараах гурван аргаар тооцоолж болно. Энэхүү гурван арга нь тооцооллын хувьд ойролцоо дүгнэлтэд хүргэдэг тул өөрт байгаа мэдээ, мэдээлэлд тулгуурлан аль тохиромжтойг нь сонгоно.

Нэг. Блок үүсгэх арга (Building Block Prudential Approach)

Блок үүсгэх аргын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараах байдлаар тооцоолно:

1. Нэгдсэн санхүүгийн тайланг ашиглан тооцооллыг хийнэ.
2. Санхүүгийн тайланг үйл ажиллагааны чиглэлээр 4 блокд (банк, даатгал, ББСБ, бусад) хэсэгчлэн хуваана.
3. Блокуудын (нэгдлийн оролцогчдын) өөрийн хөрөнгийн шаардлагын дагуу байвал зохих өөрийн хөрөнгийн дүнгүүдийг тооцоолж, нийлбэрийг олно.
4. 3-ын дагуу олсон өөрийн хөрөнгийн дүнг нэгдлийн нэгдсэн өөрийн хөрөнгөд харьцуулж, илүүдэл, дутагдлыг олно.
5. 4 нь дутагдалтай гарсан тохиолдолд нэгдлийн оролцогч хооронд хөрөнгийг шилжүүлж, дутагдлыг нөхөх боломжтой эсэхийг үнэлнэ.

ЖИШЭЭ

Толгой компани нь ББСБ бөгөөд даатгал, банк болон лизингийн компанитай банкны нэгдлийг авч үзье. Нэгдлийн оролцогч хоорондын хэлцэл, гүйлгээ байхгүй гэж үзсэн болно.

Бүрэн нэгтгэл

	ББСБ /толгой/	Банк/60% эзэмшдэг/	Даатгал	Бусад	Нэгдлийн нийт
Байвал зохих өөрийн хөрөнгө	32	17	10	10	69
Одоо байгаа өөрийн хөрөнгө	40	22	12	7	81
Илүүдэл/дутагдал	8	5	2	-3	12

- Дээрх хүснэгтэд банкны нэгдлийг 4 блокд хуваан өөрийн хөрөнгийг зохих журмын дагуу тус тусд нь тооцоолсон байна.
- Лизингийн компани нь Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаар зохицуулагддаггүй учир бусад гэсэн блокд хамрагдсан бөгөөд өөрийн хөрөнгийн тогтоосон шаардлага байхгүй учир орлуулагч утга (проху) ашиглан байвал зохих өөрийн хөрөнгийг тооцоолсон байна.
- Блокчлон авч үзэхэд ББСБ, банк, даатгалын компанийн хувьд өөрийн хөрөнгө нь байвал зохих хэмжээнээс илүүдэлтэй гарсан бол лизингийн компанийн хувьд дутагдалтай гарсан байна.
- Нэгдлийн хэмжээнд авч үзвэл өөрийн хөрөнгө нь байвал зохих хэмжээнээс илүүдэлтэй байна.
- ББСБ-аас лизингийн компанид нэмэлт хөрөнгө оруулах байдлаар дутагдлыг нөхөх боломжтой байна.

**ЖУРМЫН ТӨСӨЛ
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ**

Оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувьчлан нэгтгэсэн


	ББСБ /толгой/	Банк/60% эзэмшдэг/	Даатгал	Бусад	Нэгдлийн нийт
Байвал зохих өөрийн хөрөнгө	32	10.2	10	10	62.2
Одоо байгаа өөрийн хөрөнгө	40	13.2	12	7	72.2
Илүүдэл/дутагдал	8	3.0	2	-3	10

- Бүрэн нэгтгэлийн адилаар нэгдлийг 4 блокд хуваасан боловч банкныг нэгтгэлд хувьчилж буюу 60%-аар нэгтгэсэн.
- Нэгдлийн хэмжээнд өөрийн хөрөнгийн илүүдэлтэй байгаа бөгөөд толгой компанийн зүгээс лизингийн компанид нэмэлт хөрөнгө оруулан дутагдлыг нөхөх боломжтой байна.

Хоёр. Эрсдэлд суурилсан нэгтгэлийн арга (Risk-Based Aggregation)

Энэхүү арга нь блок үүсгэх аргатай төстэй боловч нэгдсэн санхүүгийн тайлан гаргаагүй эсвэл нэгдлийн оролцогч хоорондын хэлцэл, гүйлгээг цэвэршүүлэн тооцох боломжгүй нэгдлийн хувьд ашиглах бөгөөд дараах байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолно:

1. Банкны нэгдлийн оролцогчдын байвал зохих өөрийн хөрөнгийн хэмжээг тооцоолж, нийлбэрийг олох
2. Нэгдлийн оролцогчдын одоо байгаа өөрийн хөрөнгийн нийлбэрийг олох
3. Оролцогч хоорондоо хөрөнгө оруулсан хөрөнгийг өөрийн хөрөнгийн нийлбэрээс хасах
4. Байвал зохих өөрийн хөрөнгийн нийлбэрийг одоо байгаа өөрийн хөрөнгийн нийлбэртэй харьцуулж, өөрийн хөрөнгийн илүүдэл, дутагдлыг олох



Бүрэн нэгтгэл

	Банк/60% эзэмшдэг /	Даатгал	Лизинг	ББСБ /толгой/	Хасалт	Нэгдлийн нийт
Байвал зохих өөрийн хөрөнгө	17	10	10	32		69
Одоо байгаа өөрийн хөрөнгө	22	12	7	67	27	81

**ЖУРМЫН ТӨСӨЛ
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ**

Илүүдэл/дутагдал	5	2	-3	35	27	12
------------------	---	---	----	----	----	-----------


Оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувьчлан нэгтгэх

	Банк/60% эзэмшдэг/	Даатгал	Лизинг	ББСБ /толгой/	Хасал т	Нэгдлийн нийт
Байвал зохих өөрийн хөрөнгө	10.2	10	10	32		62.2
Одоо байгаа өөрийн хөрөнгө	13.2	12	7	67	-27	72.2
Илүүдэл/дутагдал	3.0	2	-3	35	-27	10.0

Гурав. Эрсдэлд суурилсан хорогдуулалтын арга (Risk-Based Deduction Method)

Энэхүү арга нь эрсдэлд суурилсан нэгтгэлийн аргатай төстэй боловч тооцооллыг толгой компанийн хувьд хийдэг бөгөөд оролцогч тус бүрийн өөрийн хөрөнгийн илүүдэл, дутагдалд анхаарал хандуулдаг. Энэхүү арга нь банкны нэгдлийн толгой компани нь зохицуулалттай санхүүгийн байгууллага байх тохиолдолд ашиглахад тохиромжтой. Эрсдэлд суурилсан хорогдуулалтын аргаар өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолохдоо нэгтгэлийг оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувьчлан хийх ба дараах байдлаар тооцоолно:

1. Толгой компанийн өөрийн хөрөнгөөс охин болон хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг хасч тохируулна.
2. Тохируулсан өөрийн хөрөнгө дээр оролцогч бүрийн өөрийн хөрөнгийн илүүдлийг нэмж, дутагдлыг хасна.
3. 2-ын дагуу гарсан өөрийн хөрөнгийн үзүүлэлтээс толгой компанийн байвал зохих өөрийн хөрөнгийн дүнг хасч нэгдлийн хэмжээний илүүдэл, дутагдлыг олно.



	Банк/60% эзэмшдэг/	Даатгал	Лизинг	Нэгдлийн нийт
Байвал зохих өөрийн хөрөнгө	17	10	10	62.2
Одоо байгаа өөрийн хөрөнгө	22	12	7	72.2

Илүүдэл/дутагдал	5	2	-3	10
------------------	---	---	----	----

Толгой компанийн өөрийн хөрөнгө	67
<u>Хараат компаниудад оруулсан хөрөнгийг хасах нь</u>	
Даатгал	-10
Банк	-12
Зохицуулалтгүй бусад	-5
<u>Хараат компаниудын илүүдэл/ дутагдлаар тохируулах</u>	
Даатгал	2
Банк (60%)	3
Зохицуулалтгүй бусад	-3
Толгой компанийн тохируулсан өөрийн хөрөнгө	42
Толгой компанийн байвал зохих өөрийн хөрөнгийг хасах нь	32
Нэгдэлийн өөрийн хөрөнгийн илүүдэл/ дутагдал	<u>10</u>

БАНКНЫ НЭГДЛИЙН АСУУЛГА

Банкны нэгдлийн оролцогч банкны нэр:		
Хаяг:	Утас:	
Асуулгыг бөглөсөн огноо:	Факс:	
Асуулгыг бөглөсөн ажилтны овог, нэр:	Электрон шуудангийн хаяг:	
Батлав	(овог, нэр, гарын үсэг)	Гүйцэтгэх захирал

А. Нэгдлийн ерөнхий мэдээлэл

Банкны нэгдлийн анхны оролцогч үүсгэн байгуулагдсанаас хойшхи товч түүх буюу нэгдлийн оролцогчдын үүсгэн байгуулагдсан огноо, үүсгэн байгуулагдсан нэр, голлох үйл явдлуудын талаар бичнэ үү.

Б. Хөрөнгө оруулагчид

Банкны нэгдлийн толгой компани, бүх оролцогчдын хувьд 1 болон 2-г заасан мэдээллийг оруулна уу.

..... оны-р сарын-ны өдрийн байдлаарх хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьц ааны тоо	Эзэм шлийн хувь
Аж ахуйн нэгж	Дотооды н:		
	Гадаадын		
Хувь хүн	Дотооды н:		
	Гадаады н:		
Нийт хувийн хэвшлийн хувьцаа эзэмшигчид			
Засгийн газар, төр захригааны нэгж	Дотооды н:		
	Гадаады н:		
Нийт			

Бүх хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувь, эцсийн өмчлөгчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг жагсаалтаар харуулна уу.

В. Нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, удирдлагын мэдээлэл

- 1) Банкны нэгдлийн бүтцийг диаграммаар эзэмшлийн хувьтай нь харуулна уу.
- 2) Банкны нэгдлийн удирдлагын бүтцийг диаграммаар харуулна уу.
- 3) Банкны нэгдлийн бизнесийн үйл ажиллагааны бүтцийг диаграммаар харуулна уу.
- 4) Зохицуулалтгүй болон зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч, тэдгээрийн харьяалагдах санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага, Санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага болон нэгдлийн бусад оролцогчидтой харилцах үйл ажиллагааг хариуцсан ажилтаны талаарх мэдээллийг доорх хүснэгтэд оруулна уу.

Хуулийн этгээдийн нэр	Хянан зохицуулах эрч бүхий байгууллага	Хариуцсан ажилтан
1.		
2.		
...		

- 5) Банкны нэгдлийн болон нэгдлийн оролцогчдын Төлөлөн удирдах зөвлөлийн үүрэг, хариуцлагыг бичнэ үү.

Толгой компанийн удирдлага			
Нэр	Албан тушаал	Үүрэг хариуцлага хүлээх	Бусад давхар хашдаг албан тушаал
1.			
2.			
...			

- 6) Гүцэтгэх удирдлагуудын талаарх мэдээллийг Хавсралт 1-ийн дагуу оруулж, хавсаргана уу.
- 7) Банкны нэгдлийн үйл ажиллагаа олон улсын болон хөдөө орон нутгийн түвшинд хэрхэн удирдагдаж, хянагддаг вэ?
- 8) Банкны толгой компанийн түвшинд нэгдлийн ямар үйл ажиллагааг нэгдсэн байдлаар хийдэг вэ?
- 9) Менежерүүдийн үүрэг хариуцлага, хариуцах үйл ажиллагааны чиглэл, хоорондоо хэрхэн харилцаж, хамтран ажилладаг бөгөөд удирдлагад мэдээлэх тогтолцоо нь ямар байдаг вэ?
- 10) Банкны нэгдлийн бүх оролцогчдын байгууллагын бүтцийг диаграммаар үзүүлнэ үү.
- 11) Банкны нэгдлийн оролцогчдын газар зүйн байрлал болон активын хэмжээгээрх тархалтыг диаграм/ зургаар харуулна уу.

Г. Өөрийн хөрөнгө

- 1) Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн хэмжээ.
- 2) Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийг хуваарилах стратегийг бичнэ үү.
- 3) Банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн хуваарилалтад нөлөөлдөг гол хүчин зүйлс (хянан зохицуулах байгууллагын шаардлага, эрсдэлийн хүчин зүйл г.м.) юу вэ?
- 4) Нэгдлийн оролцогчдыг хөрөнгөжүүлэхийг хэн хариуцаж, шийдвэр гаргадаг вэ?
- 5) Банкны нэгдлийн хөрөнгө хуримтлуулах, хөрөнгийг өсгөх, ногдол ашиг хуваарилах бодлогыг бичнэ үү.
- 6) Өөрийн хөрөнгөтэй холбоотой дотооддоо ашиглагддаг, удирдлагад танилцуулдаг ямар тайлангууд байдаг вэ?
- 7) Банкны нэгдлийн оролцогчид хоорондын хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хэрхэн хязгаарладаг вэ?

Д. Банкны нэгдлийн оролцогч хоорондын болон холбогдох этгээдтэй хийсэн гэрээ, хэлцэл

- 1) Нэгдлийн оролцогч хооронд үүссэн гэрээ, хэлцэл, гүйлгээний утга, зориулалт

- 2) Нэгдлийн оролцогч хоорондын гэрээ, хэлцэл, гүйлгээний дүн
- 3) Нэгдлийн оролцогч хоорондын гүйлгээ болон холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хэлцэл, гүйлгээ хийхэд баримталдаг зарчим, стратеги. Эдгээр гүйлгээг хэрхэн хянадаг вэ?
- 4) Нэгдлийн оролцогч хоорондын гүйлгээ болон холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хэлцэл, гүйлгээтэй холбоотой ямар тайлангууд боловсруулдаг, удирдлагад хэрхэн тайлагнадаг вэ? Эдгээр тайлангуудыг боловсруулдаг давтамж нь юу вэ?

Г. Эрсдэлийн удирдлага

- 1) Банк/банкны нэгдлийн эрсдэлийн удирдлагын бодлого юу вэ?
- 2) Банкны нэгдлийн голлох эрсдэлүүд юу вэ?
- 3) Банкны нэгдэл нь эрсдэлийг хэрхэн илрүүлж, тодорхойлж, үнэлж, хянаж, удирддаг вэ? Нэгдлийн эрсдэлийн үнэлгээний аргачлалын талаар бичнэ үү? Эрсдэлийн үнэлгээний загварчлал ашигладаг бол тэр талаар дурьдана уу.
- 4) Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлд эрсдэлтэй холбоотой ямар тайлангуудыг гаргаж, тайлагнадаг вэ? Эдгээр тайлангуудыг ямар давтамжийн дагуу бэлтгэдэг вэ?
- 5) Эрсдэлийн удирдлагын процессийг нэг нэгж/толгой компани төвлөрүүлэн хэрэгжүүлдэг эсхүл өөр өөр нэгжүүд/оролцогчид тус тусдаа хэрэгжүүлдэг эсэх? Аль хэсгийг нэгдсэн журмаар хэрэгжүүлдэг, аль хэсгийг тус тусдаа хэрэгжүүлдэг вэ?
- 6) Банкны нэгдлийн хэмжээнд эрсдэлийг удирдах ямар арга хэрэгсэл, механизм ашигладаг вэ? Эрсдэлийг хязгаарлах болон бусад механизмыг хэн хянадаг вэ?
- 7) Мэдрэмтгүй байдлын шинжилгээ, буцаан шалгах шинжилгээ болон болзошгүй тогтворгүй байдал үүсэх тохиолдолд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй холбоотой нэгдлийн удирдлагын арга барил, төлөвлөгөө юу вэ?
- 8) Шинэ бизнес эхлүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргахад баримталдаг бодлого, эрсдэлийн шинжилгээний талаар бичнэ үү? Тайлант жилд зах зээлд санал болгосон шинэ бүтээгдэхүүн, шинээр эхлүүлсэн бизнесийн талаар бичнэ үү.
- 9) Банкны нэгдлийн аливаа үйл ажиллагааг хөндлөнгийн компаниар гүйцэтгүүлдэг үү? Тийм бол шийдвэрийг хэрхэн гаргадаг, эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийдэг талаар бичнэ үү.

Г. Хөрвөх чадвар

- 1) Төлбөрийн чадварыг хангах, хөрвөх чадвартай холбоотой ямар бодлого баримталдаг вэ?
- 2) Хөрвөх чадварын удирдлагыг хэн хэрэгжүүлдэг вэ? Хөрвөх чадварын удирдлагын аль хэсгийг нэгдлийн хэмжээнд нэгдсэн байдлаар, аль хэсгийн тус тусдаа нэгжүүд, нэгдлийн оролцогчид хэрэгжүүлдэг вэ?
- 3) Хямралын үеийн болон тогтворжуулалтын үеийн санхүүжилтийн төлөвлөгөөг хэн гаргадаг, хариуцдаг вэ?

Г. Нягтлан бодох бүртгэл

- 1) Нягтлан бодох бүртгэлийн ямар бодлого, зарчим баримталдаг вэ?
- 2) Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой асуудлыг нэгдлийн аль хэсэг/нэгж хариуцдаг вэ?

- 3) Дээрх хэсэг/нэгжийн удирдлагын тайлагналын тогтолцоо юу вэ?
- 4) Ялгаатай нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрддөг нэгдлийн оролцогчдын мэдээг хэрхэн нэгтгэдэг вэ?
- 5) Удирдлагад тайлагнах зорилгоор ямар төрлийн тайлангууд нягтлан бодох бүртгэл хариуцдаг нэгжээс бэлтгэгддэг вэ? Ямар давтамжтайгаар бэлтгэгддэг вэ?
- 6) Санхүүгийн хяналтын үйл ажиллагаа хэрхэн явагддаг, төвлөрсөн байдлаар эсвэл нэгж/оролцогчид тус тусдаа гүйцэтгэдэг эсэх.
- 7) Дотооддоо мөрддөг санхүүгийн хязгаарлалт, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ?
- 8) Санхүүгийн жилийн эцэс хэзээ байдаг вэ?
- 9) Сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргана уу.
- 10) Банкны нэгдлийн аудитлагдсан нэгдсэн санхүүгийн тайланг хавсаргана уу.

Г. Дотоод аудит

- 1) Дотоод аудитын бодлогын талаараа бичнэ үү.
- 2) Дотоод аудитын хүрээнд ямар мэдээлэл, тайлан бэлтгэгддэг вэ?
- 3) Дотоод аудитын үйл ажиллагааг нэгдлийн хэмжээнд төвлөрсөн байдлаар хэрэгжүүлэг үү эсхүл нэгж/оролцогчид тус тусдаа гүйцэтгэдэг үү.
- 4) Дотоод аудитын үйл ажиллагааг хэнд тайлагнадаг вэ?
- 5) Дотоод аудитын зарим үйл ажиллагааг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлдэг эсэх.
- 6) Банкны нэгдлийн болон оролцогчдын сүүлийн нэг жилийн дотоод аудитын тайланг хавсаргана уу.

Г. Хөндлөнгийн аудит

- 1) Банкны нэгдэл, оролцогчдын хөндлөнгийн аудитыг гүйцэтгэдэг компани юу вэ? Хөндлөнгийн аудитын сонголтын хэн хариуцдаг вэ? Хөндлөнгийн аудитын бие даасан, хамааралгүй байдлыг хэрхэн хангадаг вэ?
- 2) Гүйцэтгэх удирдлага биш ТУЗ-ын хараат бус гишүүний хөндлөнгийн аудиттай холбоотой үүрэг, хариуцлага юу вэ?
- 3) Хөндлөнгийн аудит ямар үүрэгтэй вэ? Хөндлөнгийн аудитын талаарх дараах мэдээллийг хүснэгтэд оруулна уу.

Банкны нэгдлийн оролцогч	Хөндлөнгийн аудитын компани	Хаяг	Холбоо барих утас
1.			
2.			
...			

Г. Мэдээлэл, компьютерийн технологи

- 1) Одоо байгаа мэдээлэл, компьютерийн технологийн бүтцийг схемчилж зурна уу. Голлох системүүдин талаар дэлгэрэнгүй бичнэ үү.
- 2) Мэдээлэл, компьютерийн технологийн үйл ажиллагааг хянадаг ТУЗ-ын хороотой эсэх?
- 3) Мэдээлэл, компьютерийн технологийн удирдлага, аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдлын удирдлагатай холбоотой дотоод бодлоготой юу?
- 4) Мэдээлэл, компьютерийн технологийн эрсдэлийн үнэлгээг хийдэг үү? Хэрхэн хийдэг вэ?
- 5) Системийн хөгжүүлэлт, худалдан авалт, байршуулалтыг хийх үйл явцын дараалал, дэлгэрэнгүйг бичнэ үү.
- 6) Дотоод хяналтын үйл ажиллагаа нь мэдээлэл, компьютерийн технологийн үйл ажиллагааг хамруулдаг уу?
- 7) Банкны нэгдэл доторх мэдээлэл, компьютерийн технологитой холбоотой гэрээ хэлцэл, үйлчилгээ хийгдсэн бол дурьдана уу.